

## УЯНГА СУМЫН ЗАСАГ ДАРГА

БАТЛАВ

Б.БЯМБАДОРЖ

2024 оны 03 сарын 15-ны өдөр

**НӨӨЦӨД БЭЛТГЭХ НОГООН ТОЛГОЙТОЙ НОГООН ТЭЖЭЭЛ БОЛОН НАРИЙН НОГОО ӨВСНИЙ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

**1. Барааны тодорхойлолт :**

- Нийлүүлэх толгойтой ногоон тэжээл, нарийн ногоо өвс нь 2023 оны намрын ургацаас бэлтгэсэн ногоон, цайвар ногоон өнгөтэй, хөлдөж хөгцрөөгүй, тоос багатай элдэв үнэргүй

- Өвс цайж хөхрөөгүй, харлаж борлоогүй, чийггүй байх ёстой.

- Харлаж хөгцөрсөн, ялзарч муудсан толгойтой ногоон тэжээл, нарийн ногоон өвсийг сумын нөөцөд нийлүүлэхийг хориглоно.

**2. Баглаа боодол :** Зориулалтын баглаа боодолтой байх. Ногоон тэжээл, нарийн ногоон өвсний боодол задраагүй байх/ шаардлага хангaaгүй болон боодол задарсан толгойтой ногоон тэжээл, нарийн ногоо өвс хүлээн авахгүй.

**3. Бараа хүргэх газар:** Тухайн ачилт, буулгалт хүргэлтийн зардлыг тухайн Аж ахуйн нэгж хариуцах. Сумын аюулгүйн нөөцөд 25.000.000 төгрөг, Жаргалант багт 5,000,000 төгрөгний толгойтой ногоон тэжээл, нарийн ногоон өвс хүргэнэ.

Сумын нөөцөд нийлүүлэх ногоон тэжээл, нарийн ногоон өвсийг зориулалтын мяндсан утсаар боосон байх.

№	Үзүүлэлт	Хэмжээ, чанарын тодорхойлолт
1	Нэг боодол өвсний хэмжээ см,-ээр	50x30x80
2	Нэг боодол өвсний жин кг-аас багагүй	25
3	Нэг боодол өвсний нягтрал кг,/м3-аас багагүй	120-150 кг/м3 байхаар няйт боогдсон байна.
4	Элс шорооны хольц %-иас ихгүй	0,5%-иас ихгүй
5	Өнгө	ногоон, цайвар ногоон өнгөтэй
6	Үнэр	Өвсний өвөрмөц анхилуун үнэртэй
7	Уян чанар	Уян зөөлөн
8	Сөөг ургамал %-иас ихгүй	10
9	Хорт ба хөнөөлт ургамал, %-иас ихгүй	0,5
10	Хагд өвсний хэмжээ %-иас ихгүй	5